

## СУМЫН ТӨВИЙН БЕТОНОН ЗАМ ТАВИХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Булган аймгийн Бүрэгхангай сумын төв замын үргэлжлэл "сумын төвийн бетонон зам тавих ажил"-ыг зураг төслийг боловсруулан холбогдох стандарт нормын дагуу 2024 онд батлагдсан төсөвт багтаан хийх ба дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

### 1. Ажилд тавигдах ерөнхий шаардлага

Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг чанд мөрдөн ажиллаж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж зарцуулах
- Гүйцэтгэгч нь захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллаж шаардлагатай.
- Ажлын үе шат бүрт захиалагчийн хяналтын төлөөлөлд үзүүлж фото зургаар баталгаажуулж акт үйлдэн дараагийн ажлыг үргэлжлүүлэн хийх зөвшөөрлийг авч ажиллана.
- Ажилд хэрэглэгдэх материалуудыг талбай дээр их хэмжээгээр татахаас өмнө дээжийг захиалагчид үзүүлж зөвшилдөх зарчим баримтлан ажиллана. Захиалагчтай зөвшилцөөгүй буруу буюу чанаргүй материал авч ирж ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдлаа гүйцэтгэгч хариуцна.
- Зайлшгүй шаардлагаар материалыг өөрчлөх тохиолдолд захиалагчид албан тоотоор хандаж захиалагчаар бичгээр зөвшөөрлийг авч өөрчлөлтийг хийнэ.
- Ажлыг гүйцэтгэх үед дулаан болон холбоо, цахилгааны шугамын утас, газар доорх шугамын хоолойг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлаж хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.
- Оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажлын байр, замын гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй байдлын ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, хашаа хамгаалалтыг хийж, оршин суугчдын зорчих хэсгийг гаргаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хийж ажилтнуудыг хамгаалах хэрэгслээр бүрэн хангана.
- Орон нутгаас барилгын ажилд хэрэглэгдэх түгээмэл тархацтай ашигт малтмал болон бусад барилгын материалыг авч ашигласан тохиолдолд зохих төлбөр хураамжийг төлөх

- Ажлын явцад гарсан хог хаягдлын төвлөрсөн хог хаягдлын цэгт хаяна. Ажил дууссаны дараа тайлбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
- Ажлын график чанарын хяналтын хугацааг тооцож ирүүлэх бөгөөд хугацааг мөрдөж ажиллана.
- Ажилд тушаалаар томилогдсон мэргэжлийн тайбайн инженерийг тогтмол ажиллуулах, мэргэжил шаардсан ажилд мэргэжлийн үнэмлэхтэй ажилчдыг ажиллуулах.
- Үнийн санал ирүүлэхдээ төсвийг ЗТБХБСайдын 2012 оны 181-р тушаал, барилгын төсөв зохиох заавар, БНБД 81-95-12-ийг мөрдлөг болгох бөгөөд шууд, нэмэгдэл, ашиг, захиалагчын хяналтын зардал, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажил зэргийг тооцож ирүүлнэ.
- Ажил дууссаны дараа гүйцэтгэлийн зургийг гаргаж захиалагч болон хяналтын байгууллагад ирүүлнэ.
- Техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчын төлөөлөгч эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох "Зөрчлийн тухай хуулийн" дагуу захиргааны арга хэмжээ авах эрхтэй болно.

## **2. Ажилд хэрэглэгдэх барилгын материалд тавигдах шаардлага**

Ашиглаж буй материалууд нь чанарын хувьд олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар, стандартыг бүрэн хангасан байх.

- Барилгын материалууд нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан шинэ ашиглагдаагүй, сүүлийн үеийн дэвшилтэд технологи хандлагыг бүрэн хангасан байх бөгөөд лабораторын шинжилгээний дүнг материал татахад хамт ирүүлсэн байна.
- Орон нутгаас элс хайрга зэрэг барилгын материал авч хэрэглэх тохиолдолд заавал лабораторид шинжлүүлж орцын нормыг тодорхойлуулсан байна.
- Шаардлага хангасан шинжилгээний бичиггүй түүхий эд материалыг ажилд хэрэглэхгүй болно.

## **3. Бетонон замын ажилд тавигдах шаардлага**

- Бетонон замын ажил хийх тайлбайн ургамлын хөрсийг хуулж тэгшлэн цутгалт хийх
- Бетонон замын зорчих хэсгийн хөндлөн хэвгий 1,5%, хөвөө хэвгий 4% байна.
- Бетонон замын хашлагыг ажлын талбайд далан хийнэ.
- Бетонон замын зорчих хэсгийн өргөн 9м/хөндлөн хөвөө орсон хэмжээ/, нийт урт 1500м
- Бий болж болзошгүй үерлэлт болон урсгал усыг аюулгүй өнгөрүүлэх боломжийг урьдчилан тооцсон байх
- Ус зайлуулах хоолой, замын тэмдэг тэмдэглэгээ, гарц, гол цагаан шугам зэргийг хийнэ.

### АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
<b>Замын чиг сэргээх</b>			
1	Замын чигийг сэргээх	км	1,5
<b>Талбайн цэвэрлэгээ</b>			
2	Талбайн цэвэрлэгээ	м <sup>2</sup>	10500
<b>Газар шорооны ажил</b>			
3	Ул хөрсийн тэгшлэх нягтруулах	м <sup>2</sup>	10500
4	Тохиромжгүй материалыг ухаж ачих	м <sup>3</sup>	
<b>Хучилтын ажил</b>			
5	Бетонон замын хучилтыг хайргаар цутгаж хийх	м <sup>3</sup>	2100
6	Бетонон замын хашлага хийх, гарц гарам гаргах	у/м	1800

ХЯНАСАН:


ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Ц.МӨНХТУЛГА

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН



В.БАТХУЯГ



Булаг-Бирекхангай

Khan Bank

Узил овоо

Булаг-Бирекхангай

2024 онд тавигдах бетонон замын зураглал

Image © 2024 Maxar Technologies

Activate Windows  
Go to Settings to activate Windows.  
Google